

14. И.А.Николайчук “Старый-Хартлэнд и новый мир: альтернатива-морю или межцивилизационный мир” School of Foreign Service National University of Mongolia Mongolia's Geopolitics: past Present and Future, Proceedings of the International Conference, March, 1995, Ulaanbaatar

15. Ю.Кручкин. Выдержка из доклада “Генезис российских интересов в Монголии”, там же.

16. Gerald Robbins “The Post-Soviet Heartland: Reconsidering Mackinder”, Euroasian Studies, TICA, 3, Fall 1994

**ОХУ-ын дотоод, гадаад бодлогын
талаарх зарим ажиглалт**

Улс төр судлаач Д.Баярхүү

Энд бичсэн зүйл судлаачийн хувийн дүгнэлт тул Монгол Улсын албан ёсны бодлоготой нийлэх албагүй, уншигч болгоны сэтгэлд тэр бүр нийцэхгүй байж болохыг анхаарна уу.

Нэг. Оршлын оронд

Орос орон, орос хүн монголчуудын сэтгэлд дотно санагддаг. Өмнөд хөршөө газар дор ортол хараан зүхэж, хардаж сэрдэж байсан жилүүд тэгтлээ холдоогүй байна. Тэр үетэй харьцуулахад /бид бол тэр үеийн үзэл суртлын бүтээгдэхүүн билээ-Зох/ Оросын ард түмний талаар хэзээ ч тийм зэмлэл, гүтгэлэг, дайсагнал манай зүгээс гарахгүй мэт. Дэлхийд их бага хоёр улс, хоёр үндэстэн найрамдан нөхөрлөхийн үлгэрийг ганцхан Монгол, Зөвлөлт хоёр л үзүүлсэн гэж нотлох хүн зөндөө. Манай ахмад насныхан бүгд л тэгж ойлгож яваа. Үүнд буруу байхгүй. Тэгж ойлгуулж түүнийгээ хүн ардын толгойд дэс дараалан хийсэн нам, засгийн суртал нэвтрүүлэг үнэхээр хүчтэй байсных.

XXI зууны босгон дээр үүнийг сэргүүлсэн үзлээ би энд сийрүүлэх гэж байна. Эцсийн бүлэгт Орос ба Оросын ард түмэн манай гадаад дахь нэг баталгаа болж чадах уу, хил залгаа оршихын учир, түүнээс бидэнд тусах тусгал, ач холбогдол ирээдүйд хэрхэн эргэх вэ? гэдгийг урьдчилан таах гэж оролдоё. Оросын өнөөгийн дотоод амьдрал, эдийн засгийнх нь урвуу дэвшил /уналтыг хэлж буй- Зох/, гадаад бодлогын мухардал

зэрэгт дүгнэлт хийсний эцэст ирээдүйнх нь дүр зургийг бүдэг ч атугай гаргахыг зорив. Судлаачид төгсгөлд нь дүгнэлтээ хийдэг бол би түүнийг нь зөрчөөд эхлээд хийсүгэй. Ирээдүйн томхон дайн Оросоос дэгдэж мэдэх ба Оросын эзэнт гүрний задралын хоёр, гурав дахь үе явагдана. Эзэнт гүрний хувьд түүнийг хэрхэн хүлцэн тэвчих вэ/ Эсвэл Чеченийн дайн шиг болгоод хаях уу/ Ер нь орост лидер /удирдагч/ төрөх магадлал бараг алга. Улс төрийн гаж систем түүнийг үгүйсгэж байна. Ельцинээс хойш Оросын дотоод улс төрийн дээд эли-тийн эгнээ хагарах байх. Тэр үед иргэний дайны аюул зайлшгүй цухалзана. Гэвч ямар хүмүүсийн гарт цөмийн зөвсгийн товчлуур орох вэ/ В.Жириновский, Г.Зюганов, В.Анпилов мэтийн хүмүүст шилжиж очихгүй гэх баталгаа алга. Өлссөн, хордсон /архинд нэвчсэн ба тэжээлийн дутагдалд орсон, эсвэл дайнаас тахир дутуу эрэмдэг үлдсэн/, алдах юмгүй цайчихсан сая сая хүмүүсийн гарт дэлхийн зэр зөвсгийн нэлээд нь байна гээд төсөөлөхөд Оросыг хяналтаасаа алдчих мэт. Энэ бол ирээдүйн дайны угтвар нөхцөл билээ.

Хоёр. Лидер төрөх магадлал байхгүй.

Аливаа улс орны одоо ба ирээдүй төр засгийн эрх мэдлийг барьж буй улс төрчид, намуудаас ихээхэн шалтгаалдаг билээ. Гэтэл өнөөгийн ОХУ-ыг харъя. Улсын Думд коммунистууд, үндсэрхэг популистууд олонхи байна. Холбооны хуралд ч мөн ялгаагүй. 1991 оны ГКЧП, 1993 оны Цагаан ордны босогчид бараг бүгдээрээ Орост улс төрийн эрх мэдэлтэн болжээ. Тэд өнөөдөр төсөв батлах дээр ардчиллын эсрэг Черномырдинтэй эвсдэг гээч. Эцсийн бүлэгт Ельцин ба тэдний хоорондын уулзах цэг нэг байж л дээ. Ардчилсан нам Хөдөлгөөн Орост маш сулхан төдийгүй арай ядан амьсгаатай, тэгээд бас өөр хоорондоо ямар ч эв нэгдэлгүй байгаа. Энэ бол хоёр зууны босгон дээрхи ОХУ-ын түүхэн эмгэнэл мөн.

Улс төрийн дэглэмийн шинж төлөвийг ажихад ОХУ авторитари тал руугаа ойр юм. Жишвээс ОХУ дахь эрх барьдаг, шийдвэр гаргадаг механизм Арабын хаант засагтай орнууд, лалын дэглэмүүдээс ялгарах юмгүй. Азаар ардчиллын бэлгэ тэмдэг болсон Б.Ельцин тэр механизмыг хэрэгжүүлж байна. Нэг бие хүн солигдоход л бүх зүйл орвонгоороо эргэнэ. Тиймдээ ч Ерөнхийлөгчийн эргэн тойрны хүмүүс, түүний ивээлээр дэвшигчид уддаггүй юм. Удах ч нөхцөл алга. Яагаад

гэвэл удах тусмаа золиос болох нь нэмэгдэнэ. Удахгүйн тулд байхдаа л хийдгээ хийнэ, хийсэн нь илэрвэл өчиггүй. Энэ бол ОХУ-ын улс төрийн дээд элитийн хувь тохиолдол бөлгөө. Жишээ татья. Ердөө саяхных. Ерөнхийлөгчийн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч байсан Олег Лобов Токиогийн метронд зарины химийн довтолгоо үйлдсэн “Аум Шинрико” бүлгийнхнээс хахууль авсан нь илэрч байна.

Оросын цэргийн шинэхэн технологи, түүн дотор химийн зариныг угсрах технологи өгснөөрөө 1993 онд энэ бүлгийн сохор удирдагчийн гараас 10 сая иен, дараа нь 100 мянган доллар авчээ. Москва-Тайбэйн танхимын дарга гээд Тайваныхантай холбогдох гэтэл бүтэлгүйтээд /Аум Шинриког/ сонгон авчээ. ГЯЯ-наасаа нууцлан Тайваньтай Харилцах хууль боловсруулан азаар Ельцинээр гарын үсэг зуруулаагүй хүн л дээ. Ийм л “жулик” Ерөнхийлөгчийг хүрээлж байдаг аж. Ерөнхийлөгчийн зөвлөх асан Сергей Станкевич ИНТЕРПОЛ-ын ачаар саяхан Польшид баригдав. Тэр бас хахууль авсан нь илэрчээ. Олон улсын цагдаагийн байгууллага эрэн сурвалжлахыг бодоход хийсэн нь багадаагүй мэт. Энэ мэт мөртөө тонилсон Сосковец, Павел Грачев гээд олон хүний ирээдүйд дуулдах ялыг таахаа азная. А. Лебедь Чечений дайныг зогсоосон гавьяатан, НАТО-г эрүүл нүдээр харсан улс төрч мөн. Түүнийг авч хаях шалтаг шалтгаан үнэндээ Ельцинд байсан уу? Лебедь улс төрөөс холдсон цагаас эхлэн НАТО-гийн эсрэг хийрхэлийг төрийн дээд хэмжээнд эхлүүлсэн. Дөнгөж саяхан дэвшүүлсэн Борис Немцовт түлш эрчим хүчний яамыг хариуцуулснаараа түүнийг цэрэг-аж үйлдвэрийн хамсал, улмаар Черномырдинтэй мөргөлдүүлэх хэтийн санаа цухуйлгав бололтой. Уг нь нийгмийн салбарыг өгмөөр ярьж байсансан. Немцов гох дэгээнд орж явчлаа.

Энэ онд Засгийн газраа бүхлээр нь огцруулж, гишүүдийг нь шинэчлэн томилох зүй ёсны шаардлага байв уу? Ер нь аливаа нэг хүн дэвшвэл түүний талаар их л сүржин мэдэгдэл хийж, магтаалаар танилцуулдаг боловч тэр хүн нь сайндаа л жил тэсдэг шүү дээ.

Одоо Улсын Думын сонгуульд бэлтгэж байна. Хоёр жилд нэг удаа сонгодог хуультай тул Ерөнхийлөгч түүнийг хэзээ ч өрсөлдөгчөө болгохгүй байх бололцоотой. Думээс улс төрч төрж гадагш тэлнэ гэж байхгүй. Думын нэг намын фракцын дарга Г.Зюгановын улс төрийн намтар өндөрлөх

тийш хандлаа. Энэ мэт Дум дэх бусад намынхныг жишээлж болно. 2001 оныг хүртэл Ельцинийг огцруулах тухайд мөрөөдөөд нэмэргүй. Тэгдэг механизм байхгүй. Гэвч тэр болтол олон залуус түүний гараар орж гарах болов уу.

Немцов, Чубайс хоёрын тухайд таамаглах юм алга. Лебедь энэ гурваас дараагийн Ерөнхийлөгч тодорно гэж мухраар таамаглаж болохгүй юм. Ардчиллын бэлэг тэмдэг- Е. Гайдар, Г.Явлинский, мөн С.Шахрай нарыг эдэнтэй хамтатган Оросын элитийн дунд үе гэж үздэг. Эд бол үнэхээр 2000 оноос цааш улс төрийн тавцанд нэр цуу нь түгэх улс. Гэвч Ельцинг тэр нь залгамжлана гэж шууд нэр заах боломж алга. Хэрэв Орост ардчилал хөлөө зөв олж төлөвшвөл популизм, коммунизм, үндсэрхэг үзэлд байр байхгүй. Тэгэхдээ Оросын ирээдүйд төлөвших ардчилал нь их гүрний, эзэнт гүрний шинжийг хамт агуулсан байх тавилантай, түүнээс өөр зам байхгүй. Өөрөөр өндөрлөгт гарах гарц байхгүйтай адил.

Гурав. Армитай холбоотой байсан нь хождог

Орост өнөөг хүртэл ардчилал зөв байраа олохгүй будилж мухардаж, зарим үед цус урсгах дээр тулаад буйн гол шалтгаан бол арми ба генералитет, цэрэг-аж үйлдвэрийн хамсал юм. Энэ бол Оросын нийгмийн үндэс, эдийн засгийн үндэс бөгөөд цэргийнхний дэмжлэг бол аль ч удирдагчид амин чухал явсаар ирсэн юм. Хаант Орос, Зөвлөлт засгийн бүх жилүүдэд олон зуун жилээр хэвшиж тогтсон эвдэж болдоггүй юм энэ л байлаа. Түүнийг эвдэх гэсэн хүн юунд хүрдэгийн сонгодог жишээ Хрущев /1964 онд БХЯ, КГБ хоёр түүний эсрэг талд орсноос/, Горбачев хоёр байна. Тэд юу юу ч үгүй хоцорсон нь армийнхнаас хөндий байсанд, эсвэл тэдний зэвүүг дэндүү хүргэсэнд юм. 1957 онд БХЯ-ны сайд домогт жанжин Жуковыг 1987 онд мөн сайд маршал Соколовыг яаж шившэглэлээ, хариу нь буусан нь тэдний улс төрийн төгсгөлөөр илэрсэн юм. Горбачев 1991 оны ГКЧП-г яагаад хорьж чадсангүй вэ. Арми түүнээс урвасанд. Арми, ДЯЯ, КГБ нийлээд төрийн эргэлт хийсэнд юм. ЗХУ тарж байх үест Ерөнхий командлагчийн хувьд Горбачев юу ч хийж чадаагүй. Яагаад гэвэл генералитет Ельцинд аль хэдийнээ урвасан юм. Ельцин 1993 онд Дээд Зөвлөл, Ардын депутатуудын их хурлын байрыг яагаад танкаар дайрав? Яагаад гэвэл арми түүний талд орсных. Гэвч энэ нь

хэтэрвэл Афганы дайн, Чечений дайн мэт мунхаг явдалд хүргэдгийг бас мартаж боломгүй.

1995 онд ялалтын 50 жилийн ойг Ельцин овжин ашигласан. Арми түүний талд гэдгийг дэлхийд харуулсан. Армийн ахмад дайчид, армиараа бахархал болгодог олон нийт сонгуулийн үед Ельциний талд орсон нь 1995 оны баярын ач үр билээ. Ирээдүйд бэлтгэгдэж буй, 2000 оноос цааш улс төрд зүтгэх тэр хүмүүсийн хувьд одоо Оросын арми л гол асуудал. Е.Гайдар арми ба цэрэг-аж үйлдвэрийн хамсал руу довтолоод өөрөө юу ч үгүй хоцорсон билээ.

Оросын армид өнөөдөр нүүрлэж буй тэр аюулыг ойлгодог, засч залруулахыг боддог, анхаарал тавьдаг хүн Ельцин л байх шив. Армид хавтгайрсан цалингаа тавьдаггүй зуршил, офицеруудын ажилгүйдэл, хээл хахууль, хулгай луйвар, гэмт хэрэг 2000 он гэхэд арилаад засарчихна гэсэн итгэл хаа ч алга.

Цомхотголоор түүнийг засч чадахгүй. Цомхотгол бол ажилгүйдлийн угтвар нөхцөл, ядуурал бас армид задгайрч байгаа гээч. Сайдыг хичнээн ч солиод нэмэргүй. Одоогийн сайд удахгүй. Дараагийнх нь бас XXI зуун хүргэж чадахгүй. 2000 он хүртэл Орросын армийг армийн дайтай байлгаж байх, цэрэг-аж үйлдвэрийн хамслыг хэвээр нь ажиллуулж байх нөхцөл бол НАТО-гоор гул барин, АНУ, Өрнөд Европтой мөчөөрхөх, дэлхийн хүчний тэнцвэр дээр тоглох, түүнийг бусниулах, дотооддоо Чеченийн дайны өөр нэг хувилбар сэдэж олох явдал байж болох юм. НАТО хүрээгээ Польш, Чех, Унгараар тэлснээс үүдэх аюулыг сөрж буй нь тэр гээд хөнгөн усаар ажилладаг атомын реактор Энэтхэгт нийлүүлэх, Ираныг атомын цахилгаан станцтай болоход нь туслах гэж байна. Герман Иранаас харилцаагаа тасалж, өрнөдийнхөн Ираныг ганцаардуулах гэж буй үед Оросоос Иран руу чиглэсэн бодлого эрс идэвхжив. Энэ бол АНУ-тай мөчөөрхөж буйн жишээ. Хельсинкэд НАТО-гийн асуудлаар АНУ, ОХУ хоёрын ерөнхийлөгч золтой л заамдалдаж авсангүй. Хельсинкийн тэрхүү хэлэлцээний дараа “ОХУ+Хятад+Энэтхэг+Иран” гэсэн хачин эвсэл бүрдэж эхлэв. Энэ бол XXI зуун руу чиглэсэн, тэр зуунд хэрэгжих эвслийн эхлэл гэлтэй.

“Бүх орны эрх ашгийг дэлхийд жигд тэнцүүлэх”, “Дэлхийг олон туйлтай болгох”, “Гол болон гол биш орон гэж хуваахын эсрэг”, Шудрага зүй зохистой олон улсын шинэ дэг журам тогтоох” гэх мэтийн үгс Оросын гадаад бодлогын хэллэг

болсоор 2000 он хүрэх болов уу. Орос ийнхүү АНУ ба Өрнөд Европтой мөчөөрхөх байр сууринд шилжсэн нь Хятад, Энэтхэг, Иран мэтэд тун ашигтай юм. Хятадын хувьд ардчилал, хүний эрхийн асуудлаар байнга хүлээдэг зэмлэлийг саармагжуулахад Орос-Өрнөд хоёр хоорондоо эвдрэлцэж байх нь чухал. Энэ бол Хятадын эсрэг шүүмжлэлийг саармагжуулах гол тормоз. Хэрэв хүсвэл Орос нэг л өдөр Умард Солонгосын талд орж, тус хойгт АНУ-тай сөргөлдөх болно.

Гадагш хэн нэгэнтэй сөргөлдөж, тийш нь хөрөнгө мөнгө урсгаж байх нь Оросын армийн оршин байхын нэг үндэс, ерөөсөө арми армиараа үлдэх гол зам юм. Энэ бүхний цаана Оросын арми, цэрэг-аж үйлдвэрийн хамслын асуудал давхар шийдэгдэж байна. “Росвооружение” буюу Оросын зэвсгийг борлуулдаг улсын гол компани экспортынхоо 40 хувийг Хятад руу гаргаж байна. Үлдсэнийг нь Умард Солонгос, Иран, Ирак, Ливи, Куба, ер нь л АНУ-ын зүгээс цээрлүүлэх ёстой гэж үздэг тэр улс руу өгч магадгүй болоод байна. Ер нь зэвсэг гадагш зарах нь Орост эргээд ямар ч хор аюулгүй, яагаад гэвэл эргээд айлгах гэвэл цөмийн тогтоон барих хүч тэр чигтээ буй юм чинь гэж “Росвооружение” номлож байна. Үнэндээ улсын энэ компани л Орост цалин тавьж, уурхайчдын эсэргүүцлийг намжааж, өрийг нь барагдуулж байгаа. Гандаж гундсан армийг тэр л тэжээж тогтоож байна. Тийм учраас XXI зуунд ОХУ дэлхийн хамгийн том зэвсгийн наймаачин байх болно.

Дөрөв. Орос-Хятад: үеийн үеэрээ найрсаг хөрш байх гэнэ.

НАТО-г үзэн ядах явдал гарчигт заасан хэмжээнд хүртэл өсөх бололтой. 1992, 1996 онд Ельцин Хятад, 1994, 1997 онд БНХАУ-ын дарга Зян Зэнминь ОХУ-д айлчлах явцад гарчигт заасан мэдэгдэл гарчээ. 1997 оны намар Ельцин Бээжинд дахин очих явцад энэ мэдэгдэл цааш хэрхэн шат ахихыг урьдчилан таах арга алга. “НАТО, Кремль хоёр хүрээгээ дорно зүг рүү зэрэг тэлэх” явц давхцаж буй нь энэ. Оросын хувьд Хятадын талаар ямар ч дүгнэлтгүй мэдэгдэл хийж мэдэхээр. Ерөөсөө 1949 оноос хойш хамгийн дотно байсан үе гэж өмнөх Зөвлөлт-Хятадын харилцааны 50-иад оныг үгүйсгэв. Гэтэл Хятад тийм хамаагүй, эргээд ороогдох, маргаан тарьж мэдэх элдэв мэдэгдэл хийхээс зайлсхийж байна. “Орос-Хятадын харилцаа нь стратегийн түншлэл болохоос бус

эвсэл холбоотон биш” гэж Хятадын ГЯЯ-ны сайд Цянь Цичэнь мэдэгдэв.

Энэ бол залруулга юм. Ам халсан Ельцин хожим Орос өөрөө мухардахаар мэдэгдэл хийж буйг залруулж байгаа бололтой.

XXI зуун гараад энэ дотно харилцаа байх эсэх талаар өнөөдөр ч эргэлзээ төрж байна. Оросын өөрийнх нь улс төрчид тэгж үзэж байна. “Стратегийн түншлэл” нэрээр Орос Хятадад мөлжүүлэх, ашиглуулах замд оров гэж дүгнэж байгаа нь түгээмэл байна. АНУ дэлхийд Зэвсгийн экспортоор одоо толгой цохиж байна. Гэвч хил залгаа Мексик, Канад хоёрыг тэгтлээ түншлэлийн хэмжээнд зэвсэглээгүй гэж харьцуулав. 3000 километр урт хил дагуухи Хятадыг ингэж зэвсэглэж буй нь хэтдээ Орост юу өгөх вэ? Орос хорогдуулж баршгүй их цөмийн зэвсэгтэй байж гэж бодъё. Гэтэл Хятад нэг л өдөр төрөл арилжвал түүгээрээ далайлгах нээ.

Улам бүр өсөн нэмэгдэж буй эдийн засгийн хүч нөөцтэй, хүн ам нь XXI зуун хүрэхэд нэг тэрбум 300 саяд хүрэх Хятад, эдийн засаг нь уруудан доройтож, өрөнд баригдаж, хүмүүс нь дайжин бутарч буй Орос хоёрын хооронд “АНУ, НАТО-гийн эсрэг нөхөрлөл” босч ирж буй нь тун хэврэг суурьтай гэхээр. Улс төрийн дэглэм нь шал өөр, соёл иргэншил, шашин шүтлэг, уламжлалаар ижилсэх нийтлэг байхгүй хоёр орон шүү дээ. Оросын Дальний Восток бол ХҮШ зуунд Манжийн хааны эзэмшилд байсан, одоо Орос энэ тал дээр буулт хийж эхэлсэн, 1969 оны Даманы арал энээ тэрээ бол Оросын хувьд алдаа байж гэдгээч хүлээн зөвшөөрсөн. Энэ зурвас газрын хойд этгээдээр 8 сая орос хүн сийрэгдүүхэн сууж, ихэнх нь нутгаа орхин Уралын нуруу гавах сонирхолтой байдаг. Өмнө этгээдэд 120 сая хятад хүн чихцэлдэн сууж, хууль бусаар Орос руу шургалсаар байдаг. Энэ бол XXI зууны Орос Хятадын хилийн маргааны гол сэжүүр мөн. Хятадын өсөн нэмэгдэж буй аж үйлдвэржилтэд Оросын Сибирийн баялаг гол түүхий эд бөгөөд түүхий эдийн хавсарга гээд нэрлэхсэн ч болохгүй гэх газаргүй. Хүн ам нь сийрэгжиж, нутгаа орхин дайжин дүрвэж байгаа тогтворгүй газрыг хамгаалах, ид өрнөж буй аж үйлдвэржилт, хүн амын өсөлтөө хамгаалах хоёрын хооронд асар их зөрүү байна. Тэр бол Оросоос Миг-31, СУ-29, СУ-34, Танк-80, пуужинт мина зөөгч авсан Хятадын армийн гүйцэтгэх үүрэг, цөмийн зэвсэгтээ эрдээд хилээ хилчин нохой хоёртоо даатгаад орхисон Оросын хилийн бодлого хоёрын

ялгаа нь юм. Хэн нь хэнийгээ хянах вэ? гэдэг асуудлыг би хөндөж байна. 2020 он хүртэл хүчинтэй, 5 улсын хилийн нутагт Зэвсэгт хүчнийг хорогдуулах хэлэлцээр 7500 урт нутгийг хамарч буй гээч. Өргөн нь зурвасаараа 100 километр юм. Орос, Казахстан, Кыргызстан, Тажикистан бүгд л Хятадын дотоод хэрэгт орохгүй, хилээ тайван байлгана гэж ам өчиг өгч байна.

“Дэлхийд олон туйлт харилцаа, олон улсын шинэ дэглэм журам тогтоох тухай хамтарсан тунхаглалд” Ельцин, Зян Зэнминь нар гарын үсэг зурж, ирээдүй рүү чиглэсэн “Найрамдал хөгжлийн комисс” байгуулсанаа зарлав. “Хүйтэн дайн” дууссаны дараахи олон улсын дэг журам төлөвших шатандаа байгаа үед их гүрнүүд өөрсдийн үзэмж даацаар түүнийг бий болгох, оролцохыг зорьж буйн жишээ бол дээрхи тунхаглал юм. Хоёр туйлт бүтэц задран унахад нэг нь ялж, нөгөөх нь ялагдав. Ялагдсан нь Зөвлөлт ба түүнийг залгамжлагчид. Ялсан нь АНУ тэргүүтэй Өрнөд Европ, Япон. Энэ бол ердөө “Өрнөд” гэсэн тодотголтой. Гэтэл үүнд Оросоос гадна Хятад, Энэтхэг туйлаас сэтгэл дундуур байна. НАТО-г тэлэх асуудал үүстэл тэд дороо л хий бухимдаад байдаг байлаа. Одоо Оростой нэгдэн олон улсын тунхаглал дэвшүүлэх болов. Энэ бол XXI зууныг тэдний үзэмжээр байгуулах, эс чадвал АНУ-ынхаар явж буй дэг журмыг бусниулах, үймүүлэх, зогсооход бэлтгэх гэсэн санаа юм. Үүнийг дагалдан олон улсын харилцааны онол-практикийн асуудал ч хөдөлгөөнд орох бололтой. Урьд Зөвлөлт, Хятадын алин ч тийм онолоос цэрвүү явсан. Онолын урсгалыг өрнөдөд бий болгож, шинэчлэж байв. Жишээ нь АНУ бол реалполитик, либерал чиглэлийн хослол бүхий гадаад бодлоготой. Харилцаанд хүч чадавхи л гол шийдэгч. Тэр онолоор бол одоо дэлхий яах аргагүй ганц туйлтай. Тэр чигтээ XXI зуун хүрнэ. Гэтэл Орос, Хятад, Энэтхэг гурав олон туйлын тухай сэргүүлэн тавьж байна. АНУ шиг НҮБ-ыг чиглүүлж, Ерөнхий нарийн бичгийн даргыг нь үзэмжээрээ сонгож, НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааг тодорхойлж буй улс /туйл/ өөр хаана байна вэ?

байхгүй. Тийм учраас Орос, Хятадын яриад буй зүйл бол өөрийнхөө оршин буй орон зай дээр туйл болон үлдэх асуудал юм.

Тав. Эзэнт гүрний цаашдын задрал

Ельцин ЗСБНХУ-ын доторхи нэг бүгд найрамдах улсын удирдагчаар өрсөлдөж байхдаа ОХУ-ын бүрэлдэхүүн дэх

улсуудын хүссэн болгонд нь тусгаар тогтнолыг бэлэглэх мэтээр ярьж явсан цаг холдоогүй. Гэтэл Зөвлөлт гүрэн тарсны дараа юуны орой дээр суугаагаа гэнэт мэдэрчээ. Түүний албан тушаал бол Нэгдүгээр Петр, Николай хоёрдугаар хааныхаас дутахгүй ба үүрэг яг ижил болохыг мэдрэв. Ардчилал, зах зээл бол хоёрдугаар зэргийнх. Эзэнт гүрнийг тэлэх, ашиг сонирхлыг нь хангах тухайд л ярихаас бус юун тусгаар тогтнол засан тохинох манатай. Гэтэл ОХУ-ын субъектууд бүгд эсэргээр нь цэнэглэгдчихсэн байжээ. Горбачевын перестройка Зөвлөлтийн БНУ, автономит улс бүрт гэрэл гэгээ авчирчээ. Түүнийг арилгана гэхэд асар их үнэ төлөх байв. Ингэж төлсөн жишээ бол Чечень. Ердөө ганц нь. ОХУ-д зөвхөн үндэсний цөөнхи оршин суудаг субъектууд салж гарах гээд байгаа ч юм биш. Татарстан, Умард Кавказын улсуудыг нэрлэхээ азная. Тува, Якут, Буриадаас тусгаар тогтнол хүлээх нь даан ч бодит бус юм. Эдгээрээс гадна оросууд өөрсдөө аж төрдөг, мужууд хязгаарууд төвөөс зайлсхийж зугтаж байгаа юм. Рублийг сэргүүлэн гүйлгээ хийдэг чек вексель бий болгож байгаа, төвдөө төлдөг татвараас зайлсхийдэг атлаа, төвийн төсвөөс хэрдээ хангалттай авч алга болдог мужууд маш олон байна. Сибирийн баялагийг төвдөө мөлжүүлэхгүй гэсэн уриан дор ирээдүйн Сибирийн, Уралын, Тэнгис хавийн, Волгийн БНУ ууд мэндэлж мэдэх нээ. XXI зуунд үүсэх шинэ субъектуудын тухай ярьж байна л даа. Москва улам алслагдсан хот болж, амьдралын стандартын ялгаа ихэсч, дүрвэгсдийн нүүдэл суудал эх толгойгүй болсон нь шинэ субъект үүсэх нөхцөл гэлтэй. Төвөөс төвөгшөөх, залхах үзэгдэл газар авла. Энэ нь ОХУ-ын Ерөнхийлөгч, Улсын Дум сонгох сонгууль дээр илт харагдаж байна. Сонгогчдын идэвх тэтгэлээ унана гэж төсөөлөхөд бэрх байв. Ирээдүйн нэгэн үзэгдлийг түрүүлж хэлээд байх шиг.

Ерөнхийлөгчөөс томилогддог захирагчид бол түр зууртаа хяналт тавих суваг. Ихэнх нь төвдөө тэр бүр захирагддаггүй бололтой. Төвд өндөр албанд зүтгэхийн оронд орон нутагт багавтар суудал дээр тухтайхан суух нь дээр гэсэн үзэл чих байна. А.Руцкой губернатороор явсныг үүнтэй холбож болох юм. Энэ дэвсгэр дээр авч яривал ОХУ-ын орон нутагт улс төрийн шилжилт асар удаан явагдаж, эдийн засгийн шилжилт бараг хийгдэхгүй байна. Тэндээс XXI зуун руу чиглэсэн гэрэлтэй гэгээтэй юм олж харна гэж бараг үгүй. Хаа нэгтэй уурхайчдын ажил хаялт, эрчим хүчний хямрал, хааяа нэг нисэх онгоцны сүйрэл, цалин тавихгүйд бухимдсан багш,

эмч нарын ажил хаялт л мэдээллийн сувгаар дүүрэн. Оросын зах хязгаар үнэхээр уналтын байдалд оржээ. Хоцрогдол, гэмт хэрэг, улс үндэсний генийн сулрал хэвийн хэмжээнээс халив. Энэ байдлыг ч гадаадынхан ба “уулынхан” ашиглаж байна. Жишээ нь Алс Дорнод хавиар хятадууд худалдаа арилжааны журмаар орж суурьшиж эхэлсэн нь үүний нотолгоо. Умард Солонгосын хөлсний ажилчид ч тэр хавиар нэмэгдэж байна. Якут сахачууд байгалийн баялгаа Орост өгөх өгөхгүй дээр ширүүн маргаантай байна. Магадан, камчатка хавьд дэвшил бараг явагдсангүй. Агнуурын тэнгис, Япон тэнгис хавьд Хятадын тэнгисийн цэргийн флот бэхжиж, Орост эргээ хамгаалах хэрэгсэл улам бүр цөөрсөөр, нөгөөх Номхон далайн флотоос юу үлдэв? Ийнхүү дальний Восток төвийн хяналт хараанаас улам бүр холджээ.

Үүгээр юу харагдаж байна вэ? Уралын нуруугаар Ази Европ хоёр тив заагладаг бол Уралын нуруугаар Оросын хөгжлийн хоёр бүс зааглажээ. Москва, Санкт-Петербург, Дэлхийн хөл ихтэй хоёр их тэнгис-Хар болон Балти, ТУХН-ийн хамгийн их хөдөлгөөнтэй, харилцаатай хэсэг Уралын нурууны цаана байна. Орос-Белоруссын харилцаа XXI зууны нэгэн шинэ субъектын эхлэл болох байх. Гэвч Орос өөрөө асар ихийг алдаж байж, цаашаа интеграцид орно. Гэтэл өмнөд их хөрш Укриантай маргаантай. Хар тэнгисийн флот, Крымын хойг, цөмийн зэвсгийн асуудлаар маргаан даамжирч мэдэх юм. Орос-Белоруссын маягийн холбоог Украин эс таашаажээ. ТУХН өөрөө маргааны нэг сэдэв. Өөр хоорондоо холбоотнууд уу? гэтэл Азербайжан, Армен хоёр дайны байдалд байна. Молдова, Тажик хоёр юугаар холбогдож байгааг хэн ч мэдэхгүй гэх мэт. Орос ямагт чиглүүлэгч байсаар байхыг үл зөвшөөрөгчид дотроос нь гараад ирэхийг үгүйсгэхгүй. XX зуун руу ТУХН өнөөгийнхөө дүр төрхөөр алхвал ирээдүй нь бүр ч бүрхэг болно. Ерөөсөө цаашид олон улсын субъект байж чадах эсэхийг хэлэхэд хэцүүхэн юм. НАТО болон Умард Европтой ойртох талаар Балти хавийн улсууд багагүй чармайлт гаргаж байгаа нь яваандаа олон улсын томхон маргаан дэгдээж болзошгүй. Маргааныг дэгдээгч буюу гоморхогч нь аанай л Орос байна. Бас геополитикийн алдагдлаа нөхөхийг зорино. Тэр нь тогтвортой байдлын эсрэгээр явна. ЗСБНХУ-ын хуучин орон зай дээр тогтворгүй байдлын бүс үүснэ.